

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2021 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.9 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2020 оны 283 дугаар тогтоол зэргийг үндэслэн Улсын онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгавар, Аймгийн Засаг даргын 2020 оны 05, 06 дугаар албан даалгавруудын хэрэгжилтийн ханган сумын Засаг даргын А/01 дүгээр захирамжийг гарган сум орон нутагтаа дагаж мөрдөн ажиллаж байна.

Сумын Онцгой комисс 1 удаа хуралдаж, цаг үеийн байдал болон хууль тогтоомж, шийдвэрүүдийг хэрэгжүүлэх талаар авч хэлэлцлээ. Улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан сумын Онцгой комиссоос Шуурхай штабын хариуцлагатай жижүүр томилгоожуулан ажиллуулж байна. Улаанбаатар хотоос татан авах иргэдийн судалгааг гарган, аймгийн Онцгой комисстой хамтран татан авах ажиллагааг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2 тоот “Халдвараас урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээний тухай” тогтоол, Улсын онцгой комиссын 2021 оны 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангах үүднээс “Иргэн таны сонорт” “Ковид-19 зөвлөмж” санамж хуудаснуудыг бэлтгэн 400 ширхэгийг хэвлэж сумын иргэд болон аж ахуйн нэгжүүдэд тараан сурталчилсан.

Тус суманд ажиллаж байгаа төсвийн 5 байгууллага, 2 банк, 2 ШТС, 7 аж ахуй нэгжид QR кодыг үүсгүүлэн нэвтрэх хэсэгт байршуулж иргэдэд сурталчилан таниулах ажлыг 2021.01.04-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлээд байна. Байгууллагууд QR код уншуулан иргэдийг бүртгэх ажил тогтмолжоод байна.

ЗДТГ-аас нийт иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдийг цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байх талаар уриалга гаргаж, сумын цахим хуудас болон байгууллага, худалдаа үйлчилгээний газруудад байршуулаад байна.

Малын тоо толгойн албан татварын тухай хууль хэрэгжиж эхэлж байгаатай холбогдуулан, цахимаар болон жилийн эцсийн мал тооллоготой хамтатган 439 малчин иргэнээс санал авч, тусгай ажлын хэсэг байгуулагдан дүгнэж, сумын ИТХ-ын 2021 оны 01 дүгээр сарын 20-ны хуралдаанаар адуу-1000, үхэр-800, хонь-300, ямаа-600 төгрөгийн татвартай байхаар тус тус тогтоосон байна.

Хүүхдэд тавих хараа хяналтыг чангатгах, бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь үлдээхгүй байх, ахуйн хүрээнд архидан согтуурахгүй байх, гэр бүл, үр хүүхдээ эрсдэлд оруулахгүй байх талаарх зөвлөгөө зөвлөмжийг ЕБС, СӨБ-ын багш нартай хамтарч фейсбүүкээр видео контент бэлтгэн тархааж байна.

COVID-19 вирусээс хамгаалах ажлын хүрээнд байгууллагууд дотоод цэвэрлэгээ үйлчилгээ, ариутгал халдваргүйжүүлэлт, агааржуулалтыг өдөр бүр тогтмол хийн ажиллаж байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сар бүрийн 8-ны дотор шилэн дансанд байгууллагуудын сарын төсөв гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл бусад мэдээ мэдээллийг шивж байна.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернэтэд шивэн цахимаар илгээсэн.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Сумын төвийн нэгдсэн хогийн цэгийн хог асгаж байгаа байдалд хяналт тавьж талбайн хэмжээ солбилцол цэгүүдийг тодорхойлж, нийт талбайн хог хаягдлын эзэлхүүнийг тогтоох арга зүйг судлах ажлыг хийж Түвшинширээ сумын цахим хаягт хог хаягдлыг цэгцтэй, шахаж асгах анхааруулга мэдээг байршуулсан.

01-р сарын 10,11-ний өдрүүдэд золбин нохой устгалын ажлыг сумын төв болон хөдөөгийн багийн төвд зохион байгуулан 90 нохой устгаж, нэгдсэн хогийн цэг дээр нүх ухан ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг хийж булж устгасан.

Хувийн хэвшлийн малын эмч нар ЗДТГ, Цэцэрлэг, дэлгүүрүүдийн гадна, нийт 4800 мкв талбайд ариутгал халдваргүйтэл хийсэн байна.

Суманд ашиглаж байгаа мал угаалгын ванны судалгааг гаргаж аймгийн мал эмнэлгийн газарт хүргүүлэв. Тус суманд ашиглаж буй 5, засвар шаардлагатай 3, шаардлага хангахгүй ашиглах боломжгүй 3, зөөврийн 2, нийт 14 угаалгын ванн байна.

Аймгийн сайн малчны болзолд тодорхойлж буй 4 малчны материалыг бүрдүүлэн 1 дүгээр сарын 20-ны өдөр аймгийн ХХААГ-т хүргүүлсэн. Сумын нөөцийн өвс, тэжээлийг малчдад олгож эхлээд байна.

Сумын хүнсний худалдаа эрхэлдэг 9 дэлгүүрээс өргөн хэрэглээний барааны нөөц, үнийн мэдээг долоо хоног бүр авч байна.

Улаанбаатар хотруу хүнсний тээвэрт явж байгаа ачаа тээврийн машинуудад QR кодыг 8 иргэний автомашинд олгосон.

2020 оны өрх, хүн ам, малын жилийн эцсийн тооллогын нэгдсэн дүн 1-р сарын 6-нд эцэслэн гарлаа. Сумын хэмжээнд 830 малтай өрх, 6 тавиул малтай өрх, 4 аж ахуйн нэгжид 314713 толгой мал тооллогдсон байна. Үүнд: Тэмээ-1145, Адуу-

17355, Үхэр-15631, Хонь-163434, Ямаа-117148 толгой мал тус тус тоологдсон байна.

Нийт малд эзлэх хувийн жинг авч үзвэл тэмээ-0,3%, адуу-5,5%, үхэр-4,9%, хонь-52 %, ямаа-37,3% тус тус эзэлж байна.

Нийт хүн ам 3425 болж, өмнөх оныхоос 24 хүнээр өсөж, 2020 онд 72 хүүхэд шинээр мэндэлж, шилжин ирсэн хүн ам 29, шилжин явсан 46, нас барсан 31 хүн, шижиж ирсэн хүнээс 11 хүн нь өөрийн аймгийн сумдаас, 28 хүн нь бусад аймаг, сумдаас ирсэн байна. Шилжин явсан хүн амын 34% өөрийн аймаг дотроо, 66% гадны аймаг, сумдруу шилжин явсан ба Дорноговь аймгийн Хөвсгөл сум-1, Хэнтий аймгийн Хэрлэн сум-2 өрх шилжиж ирсэн байна.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

НИЙГМИЙН ХАЛАМЖ: Амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлыг 2 удаа хийж ахмад болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн шинээр асаргааны тэтгэмж тогтоолгох 2,асаргаа сунгуулах 5 хүний,хүнсний эрхийн бичигт хамрагдах 1 өрхийн асуудлыг хэлэлцсэн. 2021 оны 01-р сарын 07-ны ХТДҮҮ-нд 26 өрхийн 115 иргэн хамрагдаж байна. 56 ажил хайгч иргэний мэдээллийг дахин сэргээсэн. 2021 оны 1-р сараас эхлэн нийгмийн халамжийн үйлчилгээний болон ажил хайгчаар бүртгэгдсэн иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгсөн.

БОЛОВСРОЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Нийт багш суралцагчдад тараах хэвлэмэл материал /нэмэлт даалгавар/ хийж хүүхдүүдэд хүргэх ажлыг үргэлжлүүлэн хийж байна. БМДИ, БХ-ээс зохион байгуулж буй хэлэлцүүлэгт багш нар, эцэг эх, ажилтан, суралцагчдыг хамруулж байна. Өнгөрсөн 7 хоногт ахлах ангийн суралцагчдын мэргэжил сонголт, Теле хичээл ба суралцахуй ээлжит онлайн хэлэлцүүлэгт удирдлагууд багш нар хамрагдлаа. Түвшинширээ ЕБС хуудсаар дамжуулан хүүхэд багачууд, эцэг эхчүүдэд үлгэр, өгүүллэгийг тогтмол оруулж хүргэж байна. Сургуулийн Улаан загалмайн, Скаутын холбооны хүүхдийн хүүхдийн оролцооны байгууллагын суралцагчдын хүүхдүүд нь 55000 төгрөгний хүүхдийн бэлэг, хүнсний зүйлийг Б.Насанжаргалын гэр бүлд тусламж үзүүллээ. Сумын Засаг даргын ажлын хэсэг хөдөө малчин өрхүүдтэй ард иргэдтэй уулзах ажлаар явахад багш нарыг томилон ажиллуулж байна. Эхний

ээлжинд Өлзийт багт багш Ц.Батзориг бага ангийн 72, дунд ахлах ангийн 52 нийт 124 сурагчийн хэвлэмэл даалгаварыг авч явлаа.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Сумын Засаг даргын А/02 тоот захирамжийг гарган хариу арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж уг төлөвлөгөөний дагуу холбогдох ажлуудыг хийж байна. Үүнд шаардлагатай нэг удаагийн хувцас хэрэглэл, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэх зэрэг ажлуудыг шат дараатай хийж байна.

ЭМТ-ийн нөөцөд өнөөдрийн байдлаар 1 удаагийн комбинзон-240, 1 удаагийн маск-850, 1 удаагийн малгай-38ш, 1 удаагийн халад-150ш, бээлий-500, улавч-450, хормогч-4, шүүлтүүртэй маск-88ш, нүдний шил-90ш, нүүрний хаалт-47ш, ахуйн бээлий-20, усны гутал-10, цогцос хадгалах уут-1, аюултай хог хаягдлын уут-5 боодол жавелин-1500ш, хлорын шохой-15кг, санитол-10л тус тус байна.

2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдөр нэг удаагийн халад 300ш, улавч-200, хүзүүвч-300, амны хаалт-3000, АЦЦ уухаар, витамин С, глюканат кальци- тус тус хангалтаар ирээд байна.

Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. 1-р сарын амбулаторын нийт үзлэг, алсын дуудлага 9, гэрийн дуудлага 16, хэвтэн эмчлүүлэгч 8.

Эрүүл мэндийн яамнаас коронавирусын цар тахлын хүрээнд Covid-ийн тусгаарлах байрны хамгаалалт, хаалт 2 ширхэгийг хийлгээд байна.

Улсын хэмжээгээр халдварт саагийн вакциныг хийж эхэлж байгаатай холбоотой сумын хэмжээнд 1-р сарын 20-ноос хойш нийт 60 хүүхэд хамрагдаад байна.

Коронавирусын бэлэн байдалыг хангах ажлын хүрээнд тохиолдолд суурилсан дадлага сургуулалтыг 2 удаа явуулаад байна. Эрүүл мэндийн сайдын 375 тоот тушаалын дагуу давхардсан тоогоор 41 удаа аж ахуй нэгж байгууллагуудад тандалт хийгдээд байна. Халдвар хамгаалалын хувцасыг хүн бүр 20 удаа өмсөж тайлах аян явагдаж байна.

Тайлан нэгтгэсэн:

НЗЭБХМэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын даргын үүргийг
түр орлон гүйцэтгэгч Ж.Алтанцэцэг